

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2023/78/НА-СТА-ТЗШ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Мөрөн сум  
2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням  
Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо  
Утас: 88688168 Цахим хаяг: Ichinkhorloog@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	4
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	12
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	16
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	16
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	16
Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд дараах зөрчилтэй асуудал илэрлээ. Үүнд: .....	16
➤ Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарын нэгжний төлбөрт 700.0 мянган төгрөг төлсөн байна. Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.1 дэх "гар утасны зардал" заалтыг зөрчсөн байна. ....	16
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> .....	16
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	17
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	17
<b>4.5.1 Завсрын аудитын талаар</b> .....	17
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал</b> .....	18
<b>5.1 Төлбөрийн акт</b> .....	18
Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарын нэгжний төлбөрт 700.0 мянган төгрөг төлсөн байна. Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.1 дэх "гар утасны зардал" заалтыг зөрчсөн байна.....	18
<b>5.2 Албан шаардлага</b> .....	18
<b>5.2 Зөвлөмж</b> .....	18
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	19

## **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023.08.21 № 01/105  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЛАГ-ЭРДЭНЭ  
СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ё.ДАВАА  
ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 406,285.5 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь биет бус хөрөнгийн дансанд нэг мкв нь 2.0 мянган төгрөгөөр үнэлсэн 173,740 мкв 5 газар нэмж бүртгэсэн, Хөвсгөл аймгийн ОНӨГ-ын даргын тушаалаар үнэ төлбөргүй 182,016.1 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авсантай тус тус холбоотой байна.

### Аудитын гол асуудал

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын жилийн нийт төсвийн 62.8 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал эзэлж байна.

### Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ нь тайлант онд хэрэгжүүлэхээр нийт 7 зорилт 75 арга хэмжээг төлөвлөж 87.3 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>84,482,816.77</b>	<b>91,033,330.02</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>579,258.95</b>	<b>00.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	579,258.95	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>83,903,557.82</b>	<b>91,033,330.02</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>400,000.00</b>	<b>400,000.00</b>
35130	Эм боох материал	400,000.00	400,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>63,623,557.82</b>	<b>73,158,330.02</b>
35410	Бичиг хэргийн материал	1,084,100.00	1,167,100.00
35420	Аж ахуйн материал	52,817,382.83	61,364,881.83
35440	Түлш, шатах тослох материал	6,322,728.00	7,227,001.20
35470	Бусад хангамжийн материал	3,399,346.99	3,399,346.99
35600	Мал амьтад	19,880,000.00	17,475,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,323,376,605.91</b>	<b>1,729,662,085.89</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,323,376,605.91</b>	<b>1,729,662,085.89</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,272,420,355.91</b>	<b>1,331,968,085.77</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,090,456,832.00	1,204,865,732.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-181,987,979.10	-236,644,920.66
39203	Авто-тээврийн хэрэгсэл	177,538,173.55	175,618,558.55
39204	Хуримтлагдсан элэгдэл	-63,386,895.57	-81,482,448.29
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	209,132,234.20	213,540,660.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-82,182,384.44	-76,204,136.74
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,055,846.67	-11,049,694.47
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	7,500,000.00	7,500,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	134,778,371.00	160,578,371.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-38,818,026.06	-51,756,697.62
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>50,956,250.00</b>	<b>397,694,000.12</b>
39301	Програм хангамж	3,543,000.00	2,460,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,432,750.00	-1,091,999.88
39303	Бусад биет бус хөрөнгө	48,846,000.00	396,326,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,407,859,422.68</b>	<b>1,820,695,415.91</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>5,855,793.37</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>5,855,793.37</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>00.00</b>	<b>5,855,793.37</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	150,793.37
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	5,705,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,407,859,422.68</b>	<b>1,814,839,622.54</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,407,859,422.68</b>	<b>1,814,839,622.54</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,107,704,342.39	1,455,184,342.39
51101	Өмч: - төрийн	1,107,704,342.39	1,455,184,342.39
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-17,792,050.05</b>	<b>41,708,149.81</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-17,792,050.05	-17,792,050.05
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	59,500,199.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	317,947,130.34	317,947,130.34
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,407,859,422.68</b>	<b>1,820,695,415.91</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>493,518,760.00</b>	<b>778,165,444.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>20,000,000.00</b>	<b>258,064,844.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>20,000,000.00</b>	<b>258,064,844.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,000,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	20,000,000.00	00.00
120009	Бусад орлого	00.00	59,492,729.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>473,518,760.00</b>	<b>520,100,600.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>2,704,260.00</b>	<b>5,336,600.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,234,260.00	4,871,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,470,000.00	465,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>470,814,500.00</b>	<b>514,764,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	470,814,500.00	514,764,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>514,287,756.37</b>	<b>718,605,244.14</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>514,287,756.37</b>	<b>718,605,244.14</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>484,132,102.37</b>	<b>591,553,345.22</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>254,754,074.37</b>	<b>260,765,811.08</b>
210101	Үндсэн цалин	254,754,074.37	222,314,248.05
210102	Нэмэгдэл	00.00	30,624,961.03
210104	Урамшуулал	00.00	7,826,602.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>32,933,870.00</b>	<b>32,909,849.60</b>
210201	Тэтгэврийн даатгал	22,826,598.00	22,446,735.96
210202	Тэтгэмжийн даатгал	2,545,855.00	2,614,412.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,036,684.00	2,096,990.35
210204	Ажилгүйдлийн даатгал	502,248.00	522,882.49
210205	Эрүүл мэндийн даатгал	5,022,485.00	5,228,828.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>11,536,397.10</b>	<b>24,286,430.19</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,005,145.90	5,390,703.39
210302	Түлш, халаалт	6,531,251.20	18,895,726.80
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,884,685.75</b>	<b>42,951,228.33</b>
210401	Бичиг хэрэг	1,555,670.00	9,611,080.00
210402	Тээвэр, шатахуун	15,712,365.75	22,301,715.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,885,000.00	3,575,333.33
210404	Ном, хэвлэл	16,650.00	138,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	715,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	3,325,000.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	4,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,500,000.00</b>	<b>16,326,500.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	100,000.00	00.00
210604	Урсгал засвар	9,400,000.00	16,326,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>548,000.00</b>	<b>1,200,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	548,000.00	1,200,000.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>37,073,052.00</b>	<b>68,246,602.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,923,052.00	66,846,602.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	300,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	600,000.00	300,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	600,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	200,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>116,902,023.15</b>	<b>144,866,924.02</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,250,000.00	1,712,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	201,000.00	135,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	114,451,023.15	143,019,174.02
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,155,654.00</b>	<b>127,051,898.92</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>30,155,654.00</b>	<b>48,691,639.15</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,118,961.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	22,831,692.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,766,300.00	18,377,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,270,393.00	7,482,547.15
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>78,360,259.77</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	78,360,259.77
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-20,768,996.37</b>	<b>59,560,199.86</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>60,000.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	60,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-60,000.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-20,768,996.37</b>	<b>59,500,199.86</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>206,957,360.00</b>	<b>579,593,329.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>59,492,729.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	59,492,729.00
120009	Бусад орлого	00.00	59,492,729.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>206,957,360.00</b>	<b>520,100,600.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,254,260.00</b>	<b>5,336,600.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	834,260.00	4,871,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	420,000.00	465,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>205,703,100.00</b>	<b>514,764,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	205,703,100.00	514,764,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>192,561,277.33</b>	<b>544,650,790.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>192,561,277.33</b>	<b>544,650,790.00</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	169,194,977.33	417,619,411.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	122,959,019.00	259,636,908.36

210101	Үндсэн цалин	122,959,019.00	230,621,754.47
210102	Нэмэгдэл	00.00	22,281,455.89
210104	Урамшуулал	00.00	6,733,698.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>17,137,200.00</b>	<b>33,308,700.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	12,060,000.00	22,906,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,269,000.00	2,600,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,015,200.00	2,080,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	253,800.00	520,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,539,200.00	5,201,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>19,160,926.58</b>	<b>25,190,703.39</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,110,926.58	5,390,703.39
210302	Түлш, халаалт	16,050,000.00	19,800,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,421,527.75</b>	<b>24,248,784.33</b>
210401	Бичиг хэрэг	1,601,170.00	4,744,080.00
210402	Тээвэр, шатахуун	4,885,357.75	13,691,271.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	935,000.00	3,575,333.33
210404	Ном, хэвлэл	00.00	138,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	2,100,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>00.00</b>	<b>25,800,000.00</b>
210604	Урсгал засвар	00.00	25,800,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>310,000.00</b>	<b>1,200,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	310,000.00	1,200,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,106,304.00</b>	<b>44,434,315.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,556,304.00	43,034,315.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	300,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	300,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	600,000.00
210807	Газрын төлбөр	00.00	200,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>100,000.00</b>	<b>3,800,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	3,300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	500,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>23,366,300.00</b>	<b>127,031,378.92</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>23,366,300.00</b>	<b>48,671,119.15</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	22,831,692.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,766,300.00	18,377,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,600,000.00	7,462,027.15
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>78,360,259.77</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	78,360,259.77
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>14,396,082.67</b>	<b>34,942,539.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>34,942,539.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>34,942,539.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>34,942,539.00</b>
223001	Бусад хөрөнгө	00.00	30,000,000.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	4,942,539.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-34,942,539.00</b>
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>14,396,082.67</b>	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>16,896,082.67</b>	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,107,704,342.39	323,084,930.34	-90,236,770.78	1,340,552,501.95
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,107,704,342.39	323,084,930.34	-90,236,770.78	1,340,552,501.95
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-20,768,996.37	-20,768,996.37
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,107,704,342.39	317,947,130.34	-17,792,050.05	1,407,859,422.68
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,107,704,342.39	317,947,130.34	-17,792,050.05	1,407,859,422.68
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,107,704,342.39	317,947,130.34	-17,792,050.05	1,407,859,422.68
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	59,500,199.86	59,500,199.86
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,455,184,342.39	317,947,130.34	41,708,149.81	1,814,839,622.54

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	484,764,000.0	465,896,469.2	18,867,530.8	96.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	484,764,000.0	465,896,469.2	18,867,530.8	96.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	435,554,900.0	417,225,350.1	18,329,549.9	95.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	272,521,300.0	259,636,908.4	12,884,391.6	95.3
210101	Үндсэн цалин	272,521,300.0	230,621,754.5	41,899,545.5	84.6
210102	Нэмэгдэл	00.0	22,281,455.9	22,281,455.9	-
210104	Урамшуулал	00.0	6,733,698.0	-6,733,698.0	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,308,700.0	33,308,700.0	00.0	100.0
210201	Тэтгэврийн даатгал	22,906,000.0	22,906,000.0	00.0	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,600,700.0	2,600,700.0	00.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,080,500.0	2,080,500.0	00.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	520,100.0	520,100.0	00.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,201,400.0	5,201,400.0	00.0	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,622,200.0	25,190,703.4	431,496.6	98.3
210301	Гэрэл, цахилгаан	5,622,200.0	5,390,703.4	231,496.6	95.9
210302	Түлш, халаалт	20,000,000.0	19,800,000.0	200,000.0	99.0
2104	Хангамж, бараа материалын зардал	22,773,200.0	22,773,184.3	15.7	100.0
210401	Бичиг хэрэг	4,872,500.0	4,744,080.0	128,420.0	97.4
210402	Тээвэр, шатахуун	12,000,700.0	12,245,671.0	-244,971.0	102.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,600,000.0	3,545,333.3	54,666.7	98.5
210404	Ном, хэвлэл	200,000.0	138,100.0	61,900.0	69.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,100,000.0	2,100,000.0	00.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,800,000.0	25,800,000.0	00.0	100.0
210604	Урсгал засвар	25,800,000.0	25,800,000.0	00.0	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,200,000.0	1,200,000.0	00.0	100.0
210702	Дотоод албан томилолт	1,200,000.0	1,200,000.0	00.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,329,500.0	44,315,854.0	5,013,646.0	89.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,389,500.0	42,915,854.0	4,473,646.0	90.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.0	00.0	540,000.0	00.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.0	300,000.0	00.0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	300,000.0	300,000.0	00.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000.0	600,000.0	00.0	100.0
210807	Газрын төлбөр	200,000.0	200,000.0	00.0	100.0

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.0	5,000,000.0	00.0	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,500,000.0	4,500,000.0	00.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.0	500,000.0	00.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,209,100.0	48,671,119.2	537,980.9	98.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,209,100.0	48,671,119.2	537,980.9	98.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,831,700.0	22,831,692.0	08.0	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,377,400.0	18,377,400.0	00.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,000,000.0	7,462,027.2	537,972.9	93.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,000,000.0	30,000,000.0	00.0	100.0
2200	Дотоод эх үүсвэрээр	30,000,000.0	30,000,000.0	00.0	100.0
223001	Бусад хөрөнгө	30,000,000.0	30,000,000.0	00.0	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	514,764,000.0	495,896,469.2	18,867,530.8	96.3
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	514,764,000.0	495,896,469.2	18,867,530.8	96.3
132001	Орон нутгийн төсвөөс	514,764,000.0	495,896,469.2	18,867,530.8	96.3
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	26.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	03.00	03.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	00.00	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төгрөгөөр/ Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,336,600.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,336,600.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>5,336,600.00</b>
2104	Хангамж, бараа материалын зардал	1,475,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,445,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,861,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,861,000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>5,336,600.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>5,336,600.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,871,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	465,000.00
IV	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>00.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газар нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, төсөл хөтөлбөр зохион байгуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах чиг үүрэг бүхий Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын харьяа байгууллага юм.

Эрхэм зорилго: Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны стратегийн мөн чанар, хууль, тогтоомжийн хэрэгжилт, "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн засаг дарга, сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төрийн байгууллагуудын ажлыг шуурхай зохион байгуулахад удирдлагаар хангаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэхэд оршино.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:** Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ

нь үйл ажиллагаандаа дараах хууль эрх зүйн орчныг мөрдлөг болгон ажиллаж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Шүүхийн шинжилгээний тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль гэх мэт бусад хууль тогтоомжууд.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-ын даргын 2021 оны А/07 дугаар тушаалаар дотоод хяналтын ажлын хэсэгт өөрчлөлт оруулан 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. 2022 онд 3 чиглэлээр дотоод хяналтын бүрэлдэхүүн ажилласан байн. Үүнд:

- Төрийн албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлэлт
- Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт
- Өмчийн бүртгэл тооцоо

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний

үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан НББ-ийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 412,835.9 мянган төгрөгөөр буюу 29.3 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	83,903.6	91,033.3	7,129.7
Үндсэн хөрөнгө	1,323,376.6	1,729,662.1	406,285.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,407,859.4</b>	<b>1,820,695.4</b>	<b>412,835.9</b>
Өр төлбөр	0	5,855.8	5,855.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,407,859.4	1,814,839.6	406,980.2
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,407,859.4</b>	<b>1,820,695.4</b>	<b>412,835.9</b>

Дээрх хүснэгтээс харахад үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 406,285.5 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь биет бус хөрөнгийн дансанд нэг кв нь 2.0 мянган төгрөгөөр үнэлсэн 173,740 кв 5 газар орлогодсон, Хөвсгөл аймгийн ОНӨГ-ын даргын тушаалаар үнэ төлбөргүй 182,016.1 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авсантай тус тус холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 524,036.5 мянга, нийт зарлагыг 524,036.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвөөс санхүүжүүлэх дүнг 50,252.3 мянган төгрөгөөр бууруулж, 473,784.1 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 40,989.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 458,784.1 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 31,580.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх, 15,000.0 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 495,896 мянган төгрөг буюу 96.3 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

		/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт		
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	274,688.0	274,498.9	3,189.0	98.8%	
2		80106-Баг хорооны үйл ажиллагааны зардал	56,800.0	56,686.4	113,5	99,8%	
3		80112-Нийтлэг үйлчилгээ	53,377.4	42,824.1	10,533.2	80,2%	
4		80305-Биеийн тамир тэмцээн уралдааны зардал	300,0	300,0	0	100%	
5		80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	26,377.4	25,839.4	537,9	98%	
6		80815-Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдөх	22,831.7	22,831.6	0	100%	
7		81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	20,000.0	20,000.0	0	100%	
8		82801-Улсын их баяр наадам	3,000.0	3,000.0	0	100%	
9		70503-Орон нутгийн зорилгот хөрөнгө оруулалт	80918-Бусад	30,000.0	30,000.0	0	100%
10		71413-Байгал орчин хамгаалах, нөхөн сэргээх	81701-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал	27,389.5	22,915.4	4,473.6	83,7%
Нийт дүн			514,764.0	495,896.4	18,867.5	96.3%	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

1. Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 5,336.6 мянган төгрөг төвлөрүүлснээс тендерийн орлого 465.0 мянган төгрөг, хагас жилийн мал тооллогын зардал 3,271.6 мянган төгрөг, Аймгийн Засаг даргын Б/22 тушаалын дагуу урамшуулал 1,000.0 мянган төгрөг, хүүхэд хамгаалалаас 300.0 мянган төгрөг, нийтийг хамарсан ажлын хөдөлмөр халамжийн хэрэгцээ 300.0 төгрөгийн орлого тус тус орсон байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах төсвийн зарцуулалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням, аудитор Г.Ичинхорлоо нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, газрын захирал, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/50 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "бага" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 550,638.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 11,012.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд дараах зөрчилтэй асуудал илэрлээ. Үүнд:

- Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарын нэгжний төлбөрт 700.0 мянган төгрөг төлсөн байна. Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.1 дэх "гар утасны зардал" заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн асуудалд төлбөрийн акт тогтоосон.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-ын 2022 оны Шилэн дансны нэгдсэн цахим хуудсаны мэдээллээс дараах мэдээллийг түүвэрлэн шалгалаа. Үүнд:

- Тендерт шалгарсан болон шалгараагүй талаарх товч мэдээлэл
  - Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ
  - Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл
1. Дээрх асуудлын хүрээнд нийт 60 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 50 мэдээлэл, хугацаа хоцроосон 2 мэдээлэл, огт мэдээлээгүй 6 мэдээлэл, мэдээлэх хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.
  2. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг мэдээлсэн байдлыг хянахад орлогын 512,952.2 мянган төгрөгийн 12 гүйлгээнээс 10 мэдээллийг хугацаанд нь, 76,062.5 мянган төгрөгийн 2 мэдээлэл хугацаа хоцроосон байна. Зарлагын 66,929.6 мянган төгрөгийн 6 гүйлгээг огт мэдээлээгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Дээрх зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль: Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-ын 2022 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна.
2. Сангийн сайдын 2019 оны 190 дүгээр тушаал: Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас байгууллагын албан хаагчдын үр дүнгийн мөнгөн урамшуулалд 4,882.1 мянган төгрөг, сахиул ажиллуулсаны цалин урамшуулалд 2,400.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 /Төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ гэсэн заалтуудад тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Дээрх зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Засгийн газрын 43 дугаар тогтоол зөрчсөн асуудалд 25,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлсэн байна. Албан шаардлагын биелэлтийг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	25,000.0	1	25,000.0	100%
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>25,000.0</b>	<b>1</b>	<b>25,000.0</b>	<b>100%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 150,974.2 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 142,992.1 мянган төгрөгийн 1 зөрчилд 1 зөвлөмж, 7,282.1 мянган төгрөгийн 2 зөрчилд 1 албан шаардлага, 700.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

#### 5.1 Төлбөрийн акт

Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарын нэгжний төлбөрт 700.0 мянган төгрөг төлсөн байна. Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.1 дэх "гар утасны зардал" заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөж, дээрх зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

#### 5.2 Албан шаардлага

Сангийн сайдын 2019 оны 190 дүгээр тушаал: Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас байгууллагын албан хаагчдын үр дүнгийн мөнгөн урамшуулалд 4,882.1 мянган төгрөг, сахиул ажиллуулсаны цалин урамшуулалд 2,400.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 /Төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ гэсэн заалтуудад тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

#### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг мэдээлсэн байдлыг хянахад орлогын 512,952.2 мянган төгрөгийн 12 гүйлгээнээс 10 мэдээллийг хугацаанд нь, 76,062.5 мянган төгрөгийн 2 мэдээлэл хугацаа хоцроосон байна. Зарлагын 66,929.6 мянган төгрөгийн 6 гүйлгээг огт мэдээлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг хуулийн хугацаанд иж бүрэн, ил тод мэдээлж байх.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн	1	700.0	1	700.0				
Эдийн засгийн ангилал зөрчсөн	1	7,282.1			1	7,282.1		
Дүн	2	7,982.1	1	700.0	1	7,282.1		

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Орлогын гүйлгээ хугацаа хоцроосон, зарлагын гүйлгээ огт мэдээлээгүй	2							
	1	142,992.1	-	-	-	-	1	142,992.1
Дүн	1	142,992.1					1	142,992.1

### АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЫМ ОГНОО:

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО: *Ө/Н/2*

*1170*



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 17 өдөр

№ 12/20230469/ХВА-2023/78  
/НА-СТА-ТНЗ

Мөрөн сум

### Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ нь Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас байгууллагын албан хаагчдын үр дүнгийн мөнгөн урамшуулалд 4,882,027 (Дөрвөн сая найман зуун наян хоёр мянга хорин долоон) төгрөг, сахиул ажиллуулсны цалин урамшуулалд 2,400,000 (Хоёр сая дөрвөн зуун мянган) төгрөг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." гэж заасныг үндэслэн

### ШААРДАХ нь:

1. Төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэх;
2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалыг мөрдөж ажиллахыг Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ё.Даваа, нягтлан бодогч Б.Чулуун-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР:



А.ЭРДЭНЭБААТАР

Г.ИЧИНХОРЛОО

<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2023 оны 08 сарын 17 өдөр

№ 11/АЭЭ-70469/ХАА-2023/78-  
/НА-СТА-ТШЗ

Мөрөн сум

### Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга болон ЗДТГ-ын дарга нарын нэгжийн төлбөрт 700,000 /долоон зуун мянга/ төгрөг төлсөн байна.

Дээрх зөрчил нь "Төсвийн тухай хууль"-ийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалт, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Зарлагын эдийн засгийн ангилал ашиглах заавар", "Төрийн хэмнэлтийн тухай"-ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.1 дэх "гар утасны зардал" заалтуудтай тус тус нийцээгүй ба "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтуудыг үндэслэн

### ТОГТООХ нь:

1. Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-ын төсвөөс төлсөн 700,000.0 /Долоон зуун мянган/ төгрөгийг Засаг дарга З.Ням-Очир, ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ё.Даваа нараас гаргуулж Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> нотлох баримтын хамт ирүүлэхийг Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ё.Даваа, нягтлан бодогч Б.Чулуун-Эрдэнэ нарт хариуцуулав.

### ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

Г.ИЧИНХОРЛОО

<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043